

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл шаардлага

1.Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд тусгасан Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журам, шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болох зохицуулалтыг уг хуульд нийцүүлэн зохицуулах шаардлага үүсээд байна.

2.Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3-т “шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах чиглэлээр: 5.3.2-т шүүгчийг сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгож, Шүүхийн захиргааны болон Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн сайжруулна.” гэж тусгасан.

3.Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д “Шүүгчийн эрх зүйн байдлыг шинэчлэн тогтоох, шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдсэн бусад шинэтгэлтэй нийцүүлэх, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.” гэж, “Үндсэн хуулиар олгогдсон шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг баталгаатай хангахын тулд шүүхийн захиргааны чиг үүрэгтэй холбоотой хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Шүүхийн захиргааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.” гэж, Шүүгчийн ёс зүйн хорооны эрх зүйн байдлыг боловсронгуй болгож, шүүгчийн ёс зүйн зөрчил, түүнд оногдуулах хариуцлагыг тодорхой болгох үүднээс Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн төслийг боловсруулна.” гэж, “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, ажиллах журмыг нарийвчлан хуульчлах, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.” гэж тус тус тусгасан.

Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Их Хурлаас 2012 онд батлан хэрэгжүүлж байгаа Монгол Улсын шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд Хууль тогтоомжийн тухай хуульд заасанчлан хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийлгүүлсэн бөгөөд энэхүү үнэлгээгээр эдгээр хуулиудыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагын талаар дараах дүгнэлт, саналыг дэвшүүлсэн болно.

Үүнд:

1.Шүүхийн дагнасан тогтолцооноос ухрахгүй байх, цаашид шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан байгуулах, шүүгчийг мэргэшүүлэх асуудлыг хөгжүүлэх, шүүхийн эдийн засгийн баталгааг хангах үүднээс шүүхийн төсвийг бууруулахгүй байх зохицуулалтыг тусгах;

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн ярилцлага авдаг үе шатыг өөрчлөх, сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэж байгаа практикийг авч үзвэл хэрэгжилтийн хувьд хангалттай бус байгааг анхаарч Ёс зүйн хорооны үйл ажиллагааг үр нөлөөтэй, бодитой хэрэгждэг болгох;

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөлөх чадавхийг нэмэгдүүлэх, бие даасан байдлыг бэхжүүлэхийн тулд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тоог 10-аас дээш болгон нэмэгдүүлэх, Шүүгчдийн зөвлөгөөнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг сонгоход чөлөөтэй, шууд, тэгш байх зарчмыг баримталж, нууцаар санал хураах шаардлагыг хуульчлах, шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлын хамгаалалтыг сайжруулахын тулд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч томилдог зохицуулалтыг өөрчлөх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан агуулга, хүрээнээс хальсан тул Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийг шинэчлэн тодорхойлох, Шүүхийн мэргэшлийн хороо, Ёс зүйн хорооны чиг үүргийг боловсронгуй болгох;

4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр тогтоолоор Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн гол агуулга буюу “шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцуулах” зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосноор энэхүү харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах ач холбогдол буурсныг анхаарах, иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтийг шүүхийн шийдвэр гаргахад харгалзан үзэх, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан хуулиудад иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр дүгнэлт, санал зэргээр ялгаатай нэршилтэй байгаа нь практикт ойлгомжгүй байдал үүсгэж байгааг анхаарч нэр томьёог нэг мөр жигдлэх, иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн төлөөлөгчид зөвхөн “хөлс” олгохоор заасан нь хөдөө орон нутгаас иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнд албан томилолт, замын зардал зэргийг олгох эрх зүйн үндэслэлгүй байгаа тул холбогдох зохицуулалтыг тусгах.

Түүнчлэн Монгол Улсад өрнөж буй хууль, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шүүхүүдийг тойргийн журмаар байгуулахтай холбоотойгоор өмнө нь ажиллаж байсан шүүгчдийг чөлөөлж, буцаан томилох ажил зохион байгуулагдсан. Уг ажлын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Дээд шүүхээс бусад шатны шүүхийн нийт 409 шүүгчдийг чөлөөлж, буцаан томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, шийдвэрлүүлсэн байна.

Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах үүргийг Үндсэн хуулийн дагуу хүлээсэн Шүүхийн ерөнхий зөвлөл нь дагнасан шүүхийн шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр шүүхийн шүүгчээр томилуулах тухай саналыг гаргаж томилуулсан, мөн Ерөнхийлөгч шүүгч нарыг тойргийн шүүхэд нь буцаан томилохдоо нийт 409 шүүгчээс 397-г нь томилж, 12 шүүгчийг ямар нэг шалтгаан, үндэслэл дурдалгүйгээр буцаан томилоогүй тохиолдол гарсан билээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дээрх шийдвэр нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан шүүгчийн хараат бус байдлын зарчмыг хөндсөн төдийгүй Ерөнхийлөгч зарим шүүгч нарыг томилохгүйгээр шүүгчийн албан тушаалаас огцруулсан нь хууль зүйн хувьд маргаан дагуулсан үйл ажиллагаа болоод байна. Нөгөөтэйгүүр, энэ нь шүүгчийн хараат бус байдлын талаарх зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлага байгааг харуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгч бүх шатны шүүхийн шүүгч нарыг томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд 3 хүнийг нэр дэвшүүлэн илгээж байгаа нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын Үндсэн хуулийн баталгаа болоход оршиж байгаагаас бус шүүхийг харьяалах зорилго агуулгагүй. Ийнхүү харьяалан захирах боломж олгохгүй тул шүүгчийг томилох, чөлөөлөх, огцруулах, шүүгчийг өөр шүүхэд шилжүүлэн томилохыг Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар бус Шүүхийн ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснийг үндэслэж шийдвэрлэдэг Үндсэн хуулийн зохицуулалттай.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэх, дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд дурдсан хэрэгцээ шаардлагад үндэслэн эдгээр 4 хуулиар зохицуулсан харилцааг нэгтгэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгаж зохицуулна.

Нэгдүгээр бүлэгт Нийтлэг үндэслэл буюу нэр томъёоны тодорхойлолтыг дэлгэрүүлж тодорхой болгон, шүүхийн эрхэм зорилгыг боловсронгуй болгон тусгана;

Хоёрдугаар бүлэгт Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчмыг боловсронгуй болгон тусгана;

Гуравдугаар бүлэгт Монгол Улсын шүүхийн тогтолцоог Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн тодорхойлох, шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий Шүүгчдийн зөвлөлийг ажиллуулах, бүх шатны шүүхийн болон шүүгчийн болон ерөнхий шүүгчийн бүрэн эрх, Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнтэй холбоотой зохицуулалтыг тусгана;

Дөрөвдүгээр бүлэгт Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан, Ерөнхий шүүгчийн бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгон тусгана;

Тавдугаар бүлэгт давж заалдах шатны шүүх, түүний бүрэн эрх, Зургаадугаар бүлэгт анхан шатны шүүх, түүний бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтыг тус тус тусгана;

Долоодугаар бүлэгт шүүгчид тавих болзол, шаардлага, Наймдугаар бүлэгт шүүгчийг сонгон шалгаруулах томилох журам, мэргэшүүлэх, Есдүгээр бүлэгт шүүгчийн бүрэн эрх үүсэх, дуусгавар болох үндэслэл, журам, Аравдугаар бүлэгт шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах баталгаа, Арван нэгдүгээр бүлэгт шүүгчид хориглох зүйлтэй холбоотой асуудлыг тус тус тусгана;

Арван хоёрдугаар бүлэгт шүүгчид хүлээлгэх хариуцлага, үүнд шүүгчийн мэргэжлийн хариуцлагын зөрчлийг тогтоох, шүүгчид оногдуулах сахилгын шийтгэлийн төрлүүдийг тусгана;

Арван гуравдугаар бүлэгт Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тусгаж, анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэхдээ шүүх хуралдаанд оролцох иргэдийн хяналтыг сайжруулах, оролцоо итгэлийг нэмэгдүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх үүднээс иргэдийн төлөөлөгчийн тоог нэмэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр ялгаатай нэрлэгдэж байгааг /дүгнэлт, санал/ нэг мөр болгох, иргэдийн төлөөлөгчийн хөлс олгох журамд албан томилолт, замын зардал зэрэг зохицуулалтыг нэмж боловсронгуй болгон тусгана;

Арван дөрөвдүгээр бүлэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, ерөнхий зөвлөлийн 10 гишүүдийг нэр дэвшүүлж томилж, сонгох журам болон зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлагыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн тодорхой болгон хуульчилна. Түүнчлэн Шүүхийн мэргэшлийн хороо, шүүхийн захиргаа буюу Тамгын газар, шүүхийн захиргааны ажилтны эрх зүйн байдлын энэхүү бүлэгт боловсронгуй болгон тусгана.

Арван тавдугаар бүлэгт Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд заасан Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг тодорхой тусгаж, Сахилгын хороог бие даасан байдлаар ажиллуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх зохицуулалтыг тусгана;

Арван зургадугаар бүлэгт сахилгын хэргийг Шүүхийн сахилгын хороог бие даан ажиллуулах болон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд бүрэн нийцэж, шүүгч хараат бус болон хариуцлагатай байх эрх зүйн орчин улам боловсронгуй болно

Хуулийн төсөлтэй холбоотойгоор зардал гарах шаардлагатай тохиолдолд Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан аргачлалын дагуу зардлын тооцоог хийж гүйцэтгэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, бусад хуультай уялдуулан боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын

тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн захиргааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг шаардлагатай бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

